



ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД
ХЭРГИЙН ЯАМ



ХУУЛЬ ЗҮЙН
ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН



Ханнс
Зайделийн
Сан

ЭРХ ЗҮЙН МЭДЭЭЛЛИЙН НЭГДСЭН СИСТЕМ WWW.LEGALINFO.MN ЦАХИМ ХУУДАСНЫ ЛОГО БҮТЭЭХ УРАЛДААНЫ УДИРДАМЖ

Уралдааны удирдамж:

Монгол Улсын хэмжээнд хууль тогтоомжийг сурталчлах, эрх зүйн мэдээлэл бэлтгэн түгээх чиг үүргийг дагнан хэрэгжүүлдэг байгууллагын хувьд эрх зүйн актыг цуглуулах, ангилан ялгах, хадгалах, эрх зүйн мэдээллийн ил тод байдлыг хангах, хүртээмжийг нэмэгдүүлэх, хууль тогтоох болон хуулийн зарим байгууллагуудыг хамарсан нийт 120 мянга гаруй эрх зүйн актын сан бүхий хууль, эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем www.legalinfo.mn цахим хуудсыг тогтмол, найдвартай ажиллуулж байна. Энэхүү сайтыг долоо хоногт дунджаар 15000-20000 хэрэглэгч тогтмол хандаж мэдээлэл авдаг.

Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем www.legalinfo.mn цахим хуудасны логоны уралдааныг ХЗДХЯ, ХЗҮХ болон Ханнс-Зайделийн сангаас хамтран нийт уран бүтээлчдийн дунд нээлттэй зарлаж байна.

Уралдаанд ирүүлэх бүтээлд тавигдах шаардлага:

- Лого нь www.legalinfo.mn цахим хуудасны үйл ажиллагаа, онцлогийг тусгасан сэтгэлгээний өндөр түвшинд хийгдсэн байх;
- График дизайны мэргэжлийн програм дээр хийгдсэн байх;
- Логог жижгээс том руу хувиргахад харьцаа алдагдахгүй үндсэн элементүүд тод харагдаж байх;
- Уралдааны бүтээлийн эх хувь нь өндөр нягтралтай 300 pixels/inch-с дээш байх бөгөөд JPEG өргөтгөлөөр буулгаж, утга санааны тайлбарын хамт sugar@nli.gov.mn цахим хаягаар ирүүлнэ үү;
- Логоны дизайн нь хар, цагаан болон өнгөт гадаргуу дээр хэвлэгдэхэд тохиромжтой байх;
- Лого нь гар утасны аппликейшний таних тэмдэг болгон шууд хэрэглэхүйц байх;
- Лого нь видео, ном товхимол, сонин сэтгүүл, ил захидал, сурталчилгааны зурагт хуудас болон бусад материалууд дээр хэвлэгдэх боломжтой байх;

- Уран бүтээлчид зөвхөн өөрийн зохиосон дизайнаар оролцох бөгөөд бусдын бүтээл /лого/-ээс хуулсан, санаа авсан, тэдгээрийн элементийг агуулсан буюу зохиогчийн эрхийг зөрчсөн бол шалгаруулалтад оролцуулахгүй;
- Уралдаанд нэг оролцогч хэдэн ч загвараар оролцож болох бөгөөд бүтээл тус бүрийг тайлбарласан байна;
- Овог нэр, холбоо барих утасны дугаар, ажлын болон оршин суугаа хаягаа уралдаанд ирүүлж буй бүтээлийнхээ тайлбар хэсэгт тодорхой бичсэн байна.

Жич: Зөвхөн шаардлага хангасан бүтээлийн зохиогчтой эргэж холбогдоно. Уралдаанд ирсэн бүтээл ХЗҮХ-ийн архивт хадгалагдана.

Хүлээн авах хугацаа:

2020 оны 7 дугаар сарын 16-ны өдрөөс 9 дүгээр сарын 15-ны өдрийн хооронд

Шалгаруулалт

Бүтээлийг хүлээн авснаас хойш ажлын 10 хоногт багтаан шалгаруулж, шалгарсан бүтээлийг ХЗҮХ-ийн албан ёсны www.legalinfo.mn цахим хуудсаар нийтэд зарлана.

Шагнал:

Шалгарсан нэг бүтээлд 3.000.000 /гурван сая/ төгрөгийн мөнгөн шагналтай. Тус шалгарсан бүтээл нь ХЗҮХ-ийн өмч юм.

Уралдааны талаар лавлах утас: 312825, 91119838, 99270602